



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/299

Алтай хот

Хөдөө аж ахуйн ээлжит тооллогын
комиссын бүрэлдэхүүн томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн "л" дэх хэсэг, 5 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 74 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг 2022 оны 5, 6 дугаар сард багтаан зохион байгуулж, аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг өрх, аж ахуйн нэгжийг тооллогод бүрэн хамруулж, тооллогын ажилд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын явц байдалд хяналт тавьж ажиллахыг комиссын дарга (Ш.Насан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ф.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20~~22~~ оны
05 дугаар сарын 16 ны өдрийн 1684 дугаар
захирамжийн хавсралт

ХӨДӨӨ АЖ АХУЙН ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -(аймгийн Засаг даргын зөвлөх)
- Орлогч: -(Статистикийн хэлтсийн дарга)
- Гишүүд: -(Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
-(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)
-(Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйлдвэр, худалдаа,
үйлчилгээний албаны дарга)
-(Газрын харилцаа, барилга хот хот байгуулалтын газрын
дарга)
-(Статистикийн хэлтсийн мэргэжилтнүүд)
- Нарийн бичгийн дарга -(Статистикийн хэлтсийн мэргэжилтнүүд)

__оОо__